

ХБТХОХ-ИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
Б.УУГАНЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /БҮТЭН ЖИЛЭЭР/

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин /2023 он/	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Аймгийн бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх							
1.	1.1. Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд гол үүрэгтэй тэргүүлэх салбаруудыг тодорхойлж, хөгжлийн стратегийг /хэтийн, дунд хугацааны, жилийн/ хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах.	Хэрэгжилтийн хувь Тайлагнах хугацаа	89.9 хувь Хуулийн хугацаанд тайлагнасан	-	“Орхон аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-г салбарын 8, ТЕЗ-ын 34, хөтөлбөрийн 62 үр дүнг хангахаар 187 арга хэмжээтэйгээр ИТХ - ын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний 18/02 тогтоолоор батлуулсан. Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах салбар хэлэлцүүлэгт орж ажиллан Бүсчилсэн хөгжлийн бодлого, Эдийн засгийн бодлого бүлгийн тэргүүлэх салбар, чиглэлийг тодорхойлох, тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлтийг боловсруулахад заавар, зөвлөмж өгч ажилласан.	2024.01.02- 2024.12.31	100%

2.	1.2. Аймгийн хэмжээнд баримтлах хөгжлийн жилийн төлөвлөгөөг аргачлал маягтын цагалварын дагуу боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх	Цагалварын дагуу төлөвлөх 2024 оны хэрэгжилтийн хувь	Цагалварын хуваариар батлуулсан. 2023 оны биелэлт 91.3%	Цагалварын дагуу, 2024 оны биелэлт 50-аас дээш хувь хэрэгжүүлнэ.	Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-д туссан цагалварын дагуу аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын төлөвлөгөөг батлуулан, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, "Орхон аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-г боловсруулан 7 дугаар сарын 01-ний дотор ЭЗХЯ болон Төслийн нэгжид хүргүүлэн заавар, зөвлөмж авч ИТХ - ын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний 18/02 тогтоолоор хуулийн хугацаандаа батлуулсан. Эрдэнэт хотын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлт 90.5 хувьтай хэрэгжсэн. Хэрэгжилтийг холбогдох шатны хурлуудаар хэлэлцүүлэн ажилласан.	2024.01.02-2024.12.31	100%
3.	1.3. Аймгийн хэмжээнд баримтлах хөгжлийн жилийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг unelgee.gov.mn сайтад шивж оруулах	01 дүгээр сард багтаах	Хуулийн хугацаанд гүйцэтгэсэн	01 дүгээр сард багтаан гүйцэтгэсэн байна.	unelgee.gov.mn сайтад 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 8 бүлэг, 33 зорилт, 181 үйл ажиллагаагаар гаргаж хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэн хуулийн хугацаанд 90.93 хувьтай тайлагнаж баталгаажсан. Мөн 11 үндэсний үр дүн, 45 салбарын үр дүн, 181 арга хэмжээ бүхий 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг шивж хуулийн хугацаанд оруулсан.	2024.01.02-2024.02.01	100%
4.	1.4. Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим системд сумдын хөгжлийн индексийн	03 дугаар сард багтаах	Хуулийн хугацаанд гүйцэтгэсэн	03 дугаар сард багтаан	"Орон нутгийн хөгжлийн индекс" тооцох аргачлалын дагуу ерөнхий 5 төрлийн мэдээлэл, боловсролын	2024.01.02-2024.03.31	100%

	мэдээллийг 2023 оны байдлаар шинэчилж оруулах; www.ldi.nda.gov.mn			гүйцэтгэсэн байна.	салбарын 15 төрлийн мэдээлэл, эрүүл мэндийн салбарын 7 төрлийн мэдээлэл, эдийн засгийн салбарын 5 төрлийн мэдээлэл, дэд бүтцийн 7 төрлийн мэдээлэл, байгаль орчины 3, бусад 1 төрлийн тоон мэдээллийг Баян-Өндөр, Жаргалант сумын түвшинд байгууллага, аж ахуйн нэгж бүрээр 2023 оны байдлаар хуулийн хугацаанд нь гаргаж www.ldi.nda.gov.mn цахим системд оруулж баталгаажуулсан. “Орон нутгийн хөгжлийн индекс” тооцох www.ldi.nda.gov.mn сайт засвартай байсан тул 2024 оны 9-р сард системийн засвар дууссаны дараа мэдээллийг оруулсан.		
5.	1.5. Бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргаас салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.	Гэрээний хугацаанд тайлагнах Гүйцэтгэлийн хувь	Гэрээний хугацаанд тайлагнаж, гүйцэтгэл 90%-тай хэрэгжсэн.	Гэрээний хугацаанд, 50-аас дээш хувийн биелүүлнэ.	Эдийн засаг, хөгжлийн сайдтай 2024 онд хамтран ажиллах гэрээний 95.7% тай хэрэгжсэн ба хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэн ЭЗХЯ-нд 2024 оны 12-р сарын 04-ны 02/3274 тоот албан бичгээр хугацаанд нь хүргүүлсэн.	2024.01.02-2024.12.31	100%
6.	1.6. Аймгийн урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулан, батлуулж, хэрэгжүүлэх	Боловсруулж, батлуулах Гүйцэтгэлийн хувь	-	Боловсруулж, батлуулах	Орхон аймаг, Эрдэнэт хотын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад Удирдлагын академитай хамтран ажилласан ба боловсруулахад ашиглагдах 4 төрлийн шинжилгээний мэдээллийг гаргаж хүргүүлсэн.	2024.01.02-2024.12.31	90%

					Эрдэнэт-Үйлдвэр ТӨХК-тай хамтран Орхон аймаг, Эрдэнэт хотыг хөгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих “Эрдэнэт шинэ илгээлт” урт хугацааны төсөл болон үүнтэй уялдуулан төлөвлөсөн аймгийн зүгээс хэрэгжүүлэх 6 дэд төсөл, хөтөлбөрийн мэдээллийг боловсруулан иргэдэд сурталчлах, санамж бичиг байгуулах ажлыг ажлыг зохион байгуулсан.		
7.	1.7. Шинэ сэргэлтийн бодлогын Хот хөдөөгийн сэргэлт зорилтыг хангах Улаанбаатар хотоос шилжин ирэх иргэн, аж ахуйн нэгж дэмжих зорилтын хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжүүлэх	Шилжин ирсэн хүн амын хувь Төлөвлөгөөн ий гүйцэтгэлийн хувь	2.7 % 93.2 хувьтай хэрэгжүүлсэн.	Хүн амын тоо 1.2 хувь нэмэгдсэн байна. Гүйцэтгэлийн хувь 50-аас дээш байна.	Шинэ сэргэлтийн бодлогын Хот хөдөөгийн сэргэлт зорилтыг хэрэгжүүлэх Улаанбаатар хотоос шилжин ирэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих “Хамтдаа Эрдэнэтэд хөгжье” хөтөлбөрийн 2024 оны төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг төлөвлөн 100% хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт шилжин суурьшсан төрийн байгууллагын албан хаагчдийн судалгааг гарган гэрт амьдардаг 3 албан хаагчийг ЧИП төсөлд хамруулсан. Мөн шилжин суурьшсан иргэдэд мэдээлэл хүргэхээр УБХ болон Татварын газарт зурагт хуудас байршуулсан. “Солорфилм” студитай гэрээ байгуулан шилжин ирсэн иргэн аж ахуйн нэгжийг сурталчлах контент, нэвтрүүлэг, подкаст болон Эрдэнэт хотын давуу тал, амьдрах таатай орчинг харуулсан видеог бэлтгэн сурталчилсан. Мөн МУБИС-ын Архангай, Ховд аймаг дахь Багшийн сургууль, АШУУИС-ын Говь-Алтай	2024.01.02-2024.12.31	100%

					аймаг дахь салбар Анагаах Ухааны сургууль, Улаанбаатар хот дахь АШУИҮС, ШУТИС, УБИС-ийн оюутнуудад Орхон аймгаа сурталчлах, дадлага хийх нөхцөл бололцоогоор хангах талаар уулзалт зохион байгуулж, дээрх сургуулиудтай хамтран ажиллах гэрээг байгуулан ажилласан. Мөн Архангай аймгийн багшийн сургуулийн 15 оюутныг байр, дадлага хийх нөхцөлөөр ханган аймгийн сургуулиудад дадлага хийлгэх ажлыг зохион байгуулсан.		
8.	1.8. Төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах	Хэрэгжүүлэх ажлын тоо	2	2	Эдийн засаг хөгжлийн яам, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд “Бодлогын баримт бичгийг үр дүнд суурилсан арга зүйгээр боловсруулах нь” сэдэвт сургалтыг бодлогын мэргэжилтэн, байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан 100-аад албан хаагчдад зохион байгуулсан. Эдийн засаг, хөгжлийн яамны сайдын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/26 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу санал авч нэгтгэх ажил хийгдэж байна. 2024 оны 2 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Хойд бүсийн эдийн засгийн форум”-д аймгийн удирдлагууд, ИТХ-ын төлөөлөгчид, төрийн болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл	2024.01.02-2024.12.31	100%

122

					бүхий 50 гаруй төлөөлөгчдийн оролцоог ханган ажилласан. 2024 оны 10-р сарын 26-нд зохион байгуулагдсан “Бүсчилсэн хөгжлийн чуулган”-нд 11 төрийн албан хаагч, 20-иод аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн төлөөлөгч оролцож бүсийн салбар хэлэлцүүлэг, үзэсгэлэнгийн үйл ажиллагаанд оролцсон. ЭЗХЯ-ны дэргэдэх “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв”-д хүсэлт хүргүүлэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, тогтоомжийн онцлог, Орхон аймагт хэрэгжүүлэх боломж, олон улсын туршлага, тус төвийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, сургалт, хэлэлцүүлгийг 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр аймагтаа зохион байгуулсан.		
Зорилт 2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах							
9.	2.1. Хэлтсийн хариуцах чиглэлээр эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шийдвэр гаргуулахаар тавьсан асуудлыг судалж, шийдвэрлүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах	Гүйцэтгэлийн хувь	100%	70%	Хариуцах ажлын чиглэлээр эрх бүхий байгууллага, албан тушаалтан, иргэдээс шийдвэр гаргуулахаар тавьсан өргөдөл, хүсэлт, албан бичгийг судалж, удирдлагуудыг мэдээллээр ханган, зөвлөгөө авч хариуг тухай бүр нь программд оруулан хааж байна. Төрийн үйлчилгээний харилцаа хандлагыг чухалчлан, хурдан шуурхай, чирэгдэлгүй үйлчилж байна.	2024.01.02-2024.12.31	100%

10.	2.2. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангах	Гүйцэтгэлийн хувь	100%	70%	Удирдлагаас цаг үеийн шинжтэй, 7 хоногийн шуурхай хурлын, хэлтсийн шуурхай хурлуудаас өгөгдсөн үүрэг даалгавруудыг цаг хугацаанд нь биелүүлж, и-оффис программд биелэлтийг оруулан ажиллаж байна.	2024.01.02-2024.12.31	100%
11.	2.3. Аймгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн чиглэлээр холбогдох захирамжийг гаргуулан, хэрэгжилтийг хангах	Гүйцэтгэлийн хувь	100%	70%	Аймгийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр 11 захирамж боловсруулан гаргуулж, 100% хэрэгжүүлэн ажилласан.	2024.01.02-2024.12.31	100%
12.	2.4. Иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, хариу мэдэгдэх	Гүйцэтгэлийн хувь	100%	100%	Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэн хариуг албан тоот, утсаар хуулийн хугацаанд хурдан шуурхай, чирэгдэлгүй шийдвэрлэж ажилласан.	2024.01.02-2024.12.31	100%
13.	2.5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу батлагдсан мэдээ мэдээллийг нийтэд ил тод мэдээллэх	Гүйцэтгэлийн хувь	100%	100%	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу батлагдсан мэдээ мэдээллийг тухай бүр и-оффис программд оруулж, нийтэд ил тод мэдээлэн ажиллаж байна. Орхон аймаг, Эрдэнэт хотын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг батлуулж и-оффис программд хугацаанд нь оруулж, Erdenet.mn сайтад байршуулсан.	2024.01.02-2024.12.31	100%
Зорилт 3. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
1.	3.1. TAX-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай	Гүйцэтгэлийн хувь	100%	100%	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, хуулийн хугацаанд батлуулсан. Хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг сар бүрийн 5-ны өдрийн дотор, ЗГҮАХ ЗДҮАХ, ТЖҮЧ, ХЖТ, ИТХ-ын тогтоол,	2024.01.02-2024.12.31	100%

124

	бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх;				шийдвэрийн биелэлт, ЭЗХС-тай байгуулсан гэрээний хэрэгжилт, Ерөнхий сайдтай байгуулсан Батламжийн биелэлт, бусад хугацаатай албан бичгийн мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна.		
2.	3.2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Гүйцэтгэлийн хувь	100%	100%	Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, чанарын удирдлагын тогтолцооны шаардлагад нийцүүлэн ажиллаж байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2024.01.02-2024.12.31	100%
3.	3.3.Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах	Хуулийн хугацаанд	Хуулийн хугацаанд мэдүүлсэн	02 дугаар сарын дотор	meduuleg.iaac.mn сайтад 2024 оны 02 дугаар сарын 10-ны дотор хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаж холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.	2024.02.10	100%

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4		5		
Зорилт 1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1.	Байгууллагаас зохион байгуулсан сургалтанд хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэн үр дүнг уялдуулах	Хамрагдсан сургалтын тоо	5	2	1. Эдийн засаг хөгжлийн яам, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй "Монгол улсад ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төслийн хүрээнд "Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт" сургалт 2. Монгол бичгийн сургалт 3. БАОЖЯ-аас зохион байгуулсан "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох сургалт 4. 7 хоног бүр Төрийн албаны зөвлөлөөс хамтран зохион байгуулдаг 7:4:10 сургалт болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан форум, зөвлөгөөнд хамрагдсан. 5. Удирдалгын академиас зохион байгуулсан "Монгол улсын хөгжлийн бодлого-үр дүнд суурилсан төлөвлөлт, хэрэгжилт" сэдэвт сургагч багш бэлдэх сургалт, "Төрийн захиргааны албан хаагчийн манлайлал" сэдэвт сургалтад хамрагдсан. 6. Удирдалгын академын Ахлах түшмэлийн сургалт	2024.01.02-2024.12.31	100%

2.	Хууль, эрх зүйн болон бусад сургалтад хамрагдаж мэдлэгийг бие даан эзэмших	Хамрагдсан сургалтын тоо	1	1	1.2024 оны сонгуулийн тухай хуулийн сургалтад цахимаар хамрагдан, шалгалт өгч сертификат авсан.	2024.01.02-2024.12.31	100%
3.	Салбар яам болон бусад холбогдох байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах	Хамрагдсан сургалтын тоо	2	1	1. ЭЗХЯ-аас зохион байгуулсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг таниулах, хэлэлцүүлэг, зөвлөгөөнд хамрагдсан. 2. ЭЗХЯ-ны дэргэдэх "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв"-д хүсэлт хүргүүлэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, тогтоомжийн онцлог, Орхон аймагт хэрэгжүүлэх боломж, олон улсын туршлага, тус төвийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан.	2024.01.02-2024.12.31	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

..... /Б.УУГАНЦЭЦЭГ/

2024.12.04

201